



ХЭНТИЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2023 оны 11 сарын 08 өдөр

Дугаар А/64

Хэрлэн сум

Чийрэгжүүлэлтийн танхим нээхэд  
зориулж хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, аймгийн Засаг даргын 2021 оны “Албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр батлах тухай” А/19 дүгээр захирамжийн 5.2.4, 5.2.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр”-ийн хүрээнд чийрэгжүүлэлтийн танхим нээхэд зориулж 14,950,000 (арван дөрвөн сая есөн зуун тавин мянган) төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.

2. Дээрх зардлыг нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшууллын зардлаас зарцуулахыг Нягтлан бодогч (Э.Ариунтунгалагт) д зөвшөөрсүгэй.

ДАРГА



Ж.ГАНТУЛГА